



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Баярын өдрүүдэд ажиллах хуваарь  
батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын тулгар төр байгуулагдсаны 2223, Их Монгол улс байгуулагдсаны 808 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр нийслэлийн нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, соёлын арга хэмжээг зохион байгуулах, жуулчны мэдээллийн төвүүдийн байгууллагын өрөө тасалгаа, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор үндэсний их баяр наадмын өдрүүдэд ажиллах ажилтнуудын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, баяр наадмын үеэр ажиллах, бэлтгэл ажлыг хангахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын өдрүүдэд тус газрын эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлаар шуурхай шийдвэрлэх нөхцөл байдал үүссэн үед газрын дарга, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллах хариуцлагатай жижүүрт мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг ажилтнуудад, 2014 оны 07 дугаар сарын 11-ний өдөр төв цэнгэлдэх хүрээлэнд жуулчдыг мэдээллээр шуурхай хангаж, зохицуулалт хийж ажиллахыг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/-д, морь барианы газар Хүй долоон худагт зохиогдох аялал жуулчлалын арга хэмжээг удирдан зохион байгуулахыг жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/ нарт тус тус үүрэг болгосугай.


3. Баярын өдрүүдэд ажиллахад шаардагдах төсөв 560.000 /таван зуун жаран мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
 даргын 2014 оны 7 сарын 08 өдрийн  
 А/43 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР АЖИЛЛАХ  
 АЖИЛТНУУДЫН ХУВААРЬ**

2014.07.08

| д/д | Хийж хэрэгжүүлэх ажлууд   | Хугацаа                                       | Хариуцах албан тушаалтан                      | Мэдээлэл сурталчилгааны төвд              |
|-----|---|---|---|---|
| 1   | Хүй долоон худагт жуулчдад зориулсан сүүдрэвчтэй асар уламжлал болгон барих, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах | 7 дугаар сарын 09, 10, 11, 12, 13-ны өдрүүдэд | М.Баасандорж<br>Б.Жаргалан<br>Оюутан цагдаа-4 | Д.Энхбаяр<br>7 дугаар сарын 11-ний өдөр   |
| 2   | Баяр наадмын хөтөлбөрийг гадаад хэл дээр бэлтгэж тараах   | 7 дугаар сарын 11-ний өдрүүдэд                | Ө.Ариунтунгалаг<br>Оюутан цагдаа -2           |   |
| 3   | Жуулчдын секторын ойролцоо гаргах худалдаа үйлчилгээний байгууллагуудад нэмэлт шаардлага тавих                    | 7 дугаар сарын 11-ний өдөр                    | С.Туул<br>Оюутан цагдаа-2                     | Н.Алтанзаяа<br>7 дугаар сарын 12-ний өдөр |
| 4   | Баяр наадмын нээлтийн үеэр 3 дугаар хаалган дээр ажиллах  | 7 дугаар сарын 09, 10, 11-ний өдөр            | Э.Мөнхзул<br>Б.Халиун                         | М.Болортуяа<br>7 дугаар сарын 13-ний өдөр |
|     | Баяр наадмын нээлтийн үеэр 4 дүгээр хаалган дээр ажиллах  |   | Б.Оюунзул<br>Ш.Ундармаа                       |   |
|     | Баяр наадмын нээлтийн үеэр 15 дугаар хаалган дээр ажиллах   |   | Г.Гансувд<br>Д.Монголхүү                      |   |
|     | Баяр наадмын нээлтийн үеэр 5 дугаар хаалган дээр ажиллах  |   | Д.Ганболд<br>Б.Ербахыт                        |   |
| 5   | Чингисийн талбайд /Дээлтэй наадам/ монгол   | 7 дугаар сарын 13-ны өдөр                     | Бүх ажилтнууд                                 |   |



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20.../оны... сарын... өдрийн  
А/43... тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР АЖИЛЛАХ,  
БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| №        | Зардлын нэр                | Тоо хэмжээ  | 1 бүрийн үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|----------|----------------------------|---|-----------------------|-------------------|
| 1        | Унааны зардал /А92 бензин/ | VII/9, 10, 11, 12, 13-ны өдрүүдэд Хүй-7 худагт    | 60.000                | 300.000           |
| 2        |                            | VII/09,10,11-ний өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд | 50.000                | 150.000           |
| 3        |                            | VII/12,13-нд Чингисийн тайлбайд                   | 55.000                | 110.000           |
| Нийт дүн |                            |   |                       | 560.000           |

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА

Огноо:.....

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ

Огноо: 2014.07.08